



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “НАЙРАМДАЛ” ТӨСЛИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ

Төслийн нэр: Дархан-Уул аймгийн нийгэм эдийн засгийн шинэлэг тэгш хүртээмжтэй тогтвортой өсөлтийг дэмжин Европын Холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх “НАЙРАМДАЛ” төсөл

Зорилго: Сайн дурын нүүрсхүчлийн хийн зах зээл (VCM) болон Парисын хэлэлцээрийн 6-р зүйлийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх

Төслийн товч агуулга

Үндэслэл:

Дархан-Уул аймгийн засаг захиргааны зүгээс цаг уурын өөрчлөлтийг шийдвэрлэх болон тогтвортой хөгжлийн санаачилгуудыг урагшлуулах нэн чухал хэрэгцээ, шаардлага буйг хүлээн зөвшөөрч, Үндэсний хувь нэмэр (ҮХН) болон ТХЗ-уудыг(ТХЗ) нутагшуулахад анхаарлаа хандуулж байна. Монгол орны байгаль цаг уур, экосистемийн салшгүй хэсэг болох Дархан-Уул аймаг нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг бөгөөд гамшигт нөлөөллөөс ангид оршихгүй юм. Уур амьсгалын өөрчлөлтийн түүхэн чиг хандлагыг температурын өсөлтийн хамт дэлхийн хэмжээнд аваад үзвэл Монгол Улсад хамгийн хурдацтай нөлөөлж буй нь ажиглагдаж байгаа бөгөөд уур амьсгалын динамикийн бусад өөрчлөлтүүд нь хүн амын амьдрал ахуйд тухайлбал, эдийн засгийн салбар, байгалийн капиталд хүчтэй нөлөөлөл үзүүлж байна. Үүний хариу арга хэмжээ болгон Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөллийг үндэсний хэмжээнд бууруулах зорилгоор олон улсын санаачилга, төсөл, хөтөлбөрүүдтэй нягт хамтран ажиллаж байгаа хэдий ч цаг уурын бодит болон шилжилтийн эрсдэлийн цар хүрээг үнэлэх боломжийг бүрдүүлэх бодлогын болон техникийн чадавх оролцогч талуудын дунд маш бага байна.

Европын Холбооноос Дархан-Уул аймгийн ЗДТГ-тай хамтран санхүүжүүлж буй НАЙРАМДАЛ төсөл нь тус аймгийн удирдлагуудад уур амьсгалын өөрчлөлтийн төслийн бэлтгэлд дэмжлэг үзүүлэх чиглэлээр аймаг, хот, сум, дүүрэг зэрэг үндэсний бус, дэд түвшний нөхцөл байдлыг судлах таатай орчныг аль болох хурдан бөгөөд үр дүнтэйгээр бүрдүүлэх, мөн хөрөнгө оруулалтын бэлэн байдлын санал дээр үндэслэн төслүүдийг хэрэгжүүлэхэд тохирох санхүүжилт, хөрөнгө оруулалтыг эрэлхийлэх зорилгоор Европын болон олон улсын түншүүдтэй хамтран ажиллах ховорхон боломжийг олгож байна. Төслийн бэлтгэл ажлыг хангаж, багц төсөл хэрэгжүүлэхэд бэлдэх үе шатанд тус санаачилгын зүгээс засгийн газар болон түүнд хамаарах байгууллагууд, төслийг боловсруулах, төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх байгууллагууд болон хувийн хэвшлийнхэнтэй хамтран санхүүжүүлэгч байгууллагуудын шаардлагыг хангасан, хөрөнгө оруулалт хийхэд бэлэн, тогтвортой хөгжлийн шилжилтэд хүрэх зам болон эдийн засгийн тогтолцоог бий болгох уур амьсгалын төслүүдийг хэрэгжүүлэхэд нь Дархан-Уул аймагт туслах юм.

Дархан-Уул аймгийн хувьд ирээдүйг бодолцсон арга барилыг судлан, нэвтрүүлснээр Нүүрсхүчлийн хийн сайн дурын зах зээл, Парисын хэлэлцээрийн 6-р зүйл, ҮХН-үүд болон бусад хоёр талт хамтарсан хөтөлбөрүүдийн (хамтарсан кредит олгох механизм буюу JCM, Солонгосын нүүрсхүчлийн хийн арилжааны схем буюу KETS гэх мэт) хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн хөрөнгө оруулалтын чиглэлээр урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ хийхэд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төслүүдийг нэн тэргүүнд авч үзэх зорилго бүхий эхэн үеийн олон санаачилгад оролцож, тэдгээрийг төлөвлөн, хэрэгжүүлэх боломжтой болсон. Тус аймгийн захиргаа нь олон улсын нүүрсхүчлийн хийн зах зээлийн динамик мөн чанарыг хүлээн зөвшөөрч, нүүрсхүчлийн хийн зах

зээлийн олон улсын оролцогчид, тэр дундаа төр, хувийн хэвшил, хөгжлийн санхүүгийн байгууллагууд болон зах зээлд суурилсан механизмын хөшүүрэг бүхий уур амьсгалын санхүүжилтын хэрэгслүүдийг нэвтрүүлэн ашиглахыг зорьж буй уур амьсгал, нүүрсхүчлийн хийн сангуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхээр идэвхтэй ажиллаж байна.

4.1 Ус, хог хаягдал, эрчим хүчний чиглэлийн (нийгмийн дэд бүтцийг бий болгох) төсөл-1

Олон нийтийн оролцоонд суурилсан, нийтлэг үйлчилгээний дэд бүтцийг бий болгох, ус, хог, хаягдал, тогтвортой эрчим хүчний хүртээмжийг хангах чиглэлтэй байна. Төсөл нь гүйцэтгэлийн стандарт, үр дүнд суурилсан стандартыг хангах, 24/7 үйлчилгээ, гомдол барагдуулах механизм гэх мэт нийтлэг үйлчилгээг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулахад чиглэнэ. Мөн түүнчлэн эдгээр төслүүд нь хуванцар болон электрон хог хаягдал, богино хугацаанд хүчтэй нөлөөлөл үзүүлдэг бохирдуулагчид (метан, хар нүүрстөрөгч) зэргийг ногоон технологийн инновац, загварчлал, платформ хөгжүүлэлт, тогтвортой хотжилтын үйл ажиллагаа явуулахад түлхэц болох өгөгдлийн сан бүрдүүлэхтэй холбосон байгаль орчинд ээлтэй менежменттэй байна.

4.2 Нийгэм, мэдээллийн технологийн энтрепренершипыг дэмжих төсөл -1

Нийгмийн тэгш, хүртээмжтэй байдлыг дэмжихэд чиглэсэн инновацад суурилсан энтрепренершипыг дэмжсэн төсөл байна. Төсөл нь баг, сумын түвшинд иргэдийн оролцоог сайжруулах, нийгмийн хүртээмжтэй байдлыг бий болгохоос эхлээд байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, эрүүл ахуй, хүнс үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, орон байр зэрэг тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх төслийг хамтран хэрэгжүүлэх сонирхолтой Монгол Улс, Европын холбооны гишүүн орнууд болон азийн орнуудаас сонирхсон байгууллагууд, консорциум, багийг урьж байна.

Зорилтууд:


Энэхүү ажлын даалгаврыг дараах зорилтуудыг биелүүлэхээр гаргасан болно:

Үндсэн зорилт:

- Дархан-Уул аймгийн нүүрсхүчлийн хийн кредит үүсгэх чадавхыг урьдчилан тодорхойлж, тогтоох иж бүрэн ТЭЗҮ хийх. Энэхүү судалгаа нь Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт нүүрсхүчлийн хийн кредит үүсгэх, мөнгөжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа болон оролцоог хамарсан институцийн тогтолцоог бий болгоно.
- Шалгуур хангасан төслүүдийн урьдчилсан ТЭЗҮ/ТЭЗҮ-ийг хийх, нүүрсхүчлийн хийг бууруулах ба/буюу арилгах схемийн шаардлага хангасан нүүрсхүчлийн хийн кредитийн төслүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн загварчлал гаргах.
- Аль болох ТЭЗҮ дээр суурилсан төслийн урьдчилсан баримт бичиг боловсруулах.
- Нүүрсхүчлийн хий ялгаруулахаас зайлсхийх, нүүрсхүчлийн хий ялгаруулалтыг арилгах чиглэлийн одоо ашиглагдаж буй стандартуудыг хэрэгжүүлэн, батлан харуулж, төслийн гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлагуудыг хангах.
- ЕХ-ны нүүрсхүчлийн хий ялгаруулахаас зайлсхийх, нүүрсхүчлийн хийг арилгах схемийг хамтын ажиллагааны түншлэлд ашиглах боломжтой эсэхийг шалгах

Хамрах хүрээ:

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн дурын нүүрсхүчлийн хийн стандартуудад үндэслэн бүх боломжит төсөл, хөтөлбөрүүдийг үнэлж, хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгнө; жишээ нь: VERPA (VERRA) болон Гөүлд (Gold) стандартууд.



Гөүлд (Gold) стандарт

Баталгаажсан нүүрсхүчлийн хийн стандартын салбарын хамрах хүрээ

Төсөл, үйл ажиллагаа, арга зүйг баталгаажсан нүүрсхүчлийн хийн стандартын дараах 16 салбарын хамран хүрээнд боловсруулан хэрэгжүүлэх боломжтой.

1. Эрчим хүч (сэргээгдэх / сэргээгдэхгүй)
2. Эрчим хүч түгээх
3. Эрчим хүчний эрэлт
4. Боловсруулах аж үйлдвэр
5. Химийн аж үйлдвэр
6. Барилга байгууламж
7. Тээвэр
8. Уул уурхай / эрдэс баялгийн үйлдвэрлэл
9. Метал үйлдвэрлэл
10. Дэгдэмхий хий – түлш шатахууны (хатуу, тос, хий)
11. Дэгдэмхий хий – аж үйлдвэрийн хий (галогент нүүрс устөрөгч, хүхрийн гексафторид)
12. Уусгагч ашиглалт
13. Хог хаягдлыг боловсруулах, устгах
14. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон бусад газар ашиглалт
15. Мал, бууцын менежмент
16. Хүлэмжийн хийг шингээн авч, хадгалах

ВЕРРА (VERRA) стандарт

Ажлын даалгавар:

- Суурь өгөгдөл цуглуулах:
 - Стандарт, төслийн төрөл, тохирох аргачлалын хүрээнд одоогийн нүүрсхүчлийн хийн ялгаруулалт болон суурь ялгаруулалтын иж бүрэн дүн шинжилгээ
- Оролцогч талуудтай зөвлөлдөх:
 - Холбогдох оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт, семинар зохион байгуулж, явуулах
 - ТЭЗҮ-ийн судалгааг мэдээллээр хангах зорилгоор санал хүсэлт, мэдээлэл, дүгнэлтийг баримтжуулах.
 - Нүүрсхүчлийн хийн кредитийн стандартуудыг нягтлан судлах:
 - Бүх оролцогч талуудтай зөвшилцсөн арга барилд үндэслэн нүүрсхүчлийн хийн кредитийн дэлхийн стандартуудыг нарийвчлан судлах.
 - Уур амьсгалын хамтын ашиг, ногоон санхүүжилтийн хүрээнд хөрөнгө оруулагчид болон Монголын оролцогч талуудын хувьд стандартын хэрэглэгдэх байдал, үр өгөөжийн үнэлгээ.
 - Техникийн үндэслэлийн тайлан:
 - Нүүрсхүчлийн хийн кредитийн боломж, хэрэгжүүлэх зөвлөмжийг нарийвчлан тусгасан иж бүрэн тайлангийн төсөл буюу урьдчилсан баримт бичгийг бэлтгэх.
 - Арилжааны зах зээлд хэрэгжих боломжтой байдлын үнэлгээ:
 - Төслийн зардал, орлогыг тодорхойлон харуулсан санхүүгийн загвар боловсруулах.
 - Одоогийн цэвэр үнэлэмж (NPV), өгөөжийн дотоод хувь (IRR), эргэн төлөгдөх хугацаа зэрэг хэрэгжих боломжийг илтгэсэн үзүүлэлтүүдийн үнэлгээ.
 - Ажил үйлчилгээний бүтэц:

- Хууль журмын нийцэл болон сайн дурын зах зээлийн стандартыг хангаж, гүйлгээний бүтэц, хөрөнгө оруулалтын шийдвэрийг удирдан чиглүүлэх дүн шинжилгээ, зөвлөмж.

- Зөвлөмж болон тогтолцоо боловсруулах:

- Дархан-Уул болон Монгол Улсын бусад аймгуудад нүүрсхүчлийн хийн арилжаа явуулах тодорхой зөвлөмж, хэрэгжүүлэх боломжтой тогтолцоо боловсруулахад чиглэсэн үр дүнгийн нэгтгэл болон хөрөнгө оруулалтыг хаах төслийн урьдчилсан баримт бичгийн боловсруулалт.

Хугацааны график:

Ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг 6 сарын дотор дуусгавар болгохоор төлөвлөсөн хэдий ч төслийн шаардлага, оролцогч талуудын санал хүсэлтэд үндэслэн өөрчлөх боломжтой. Даалгаврын хамгийн дээд хугацаа нь гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 9 сар байна.

Шаардлага:

- Шалгуур:

- Зөвлөх компани нь Европын Холбоонд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг эсвэл ЕХ-ны дүрэм журам, стандартын дагуу төсөл хэрэгжүүлэх туршлагатай байх ёстой.

- Зөвлөх баг нь нүүрсхүчлийн хийн зах зээл, төр-хувийн хэвшлийн түншлэл, төслийн санхүүжилт, хуулийн зөвлөгөө, оролцогч талуудын оролцоо зэрэг чиглэлээр батлагдсан мэдлэг чадвартай, ижил төстэй төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай байх ёстой.

- Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах төслүүдэд, болж өгвөл нэгээс олон тооны шалгуур хангасан чиглэлээр, гүйлгээний үйл ажиллагааны зөвлөх үйлчилгээ эрхэлж байсан туршлагатай.

- Зөвлөх компани нь санхүүгийн тогтвортой байдлаа батлан харуулж, өмнө нь амжилттай хэрэгжсэн төслийн нотолгоог холбогдох лавлагаа, кейс судалгаагаар дамжуулан гаргаж өгнө.

- ЕХ-ны дүрэм журмыг дагаж мөрдөх:

- Зөвлөх компани болон түүний багийн гишүүд нь төслийн бүх хугацаанд ЕХ-ны холбогдох бүх дүрэм журам, заавар, худалдан авалтын дүрмийг дагаж мөрдөх ёстой.

- Зөвлөх компани нь ЕХ-ны авлигатай тэмцэх арга хэмжээний дагуу төсөлтэй холбоотой бүхий л үйл ажиллагаа, ажил гүйлгээний ил тод, хариуцлагатай, шударга байдлыг хангах ёстой.

- Хэлний чадвар:

- Тайлан, илтгэл, оролцогч талуудын оролцоо зэрэг бүх бичгийн болон аман харилцаанд англи хэлний өндөр мэдлэгтэй байх шаардлагатай. Ноогдсон үүрэг даалгаврыг найрамдал төсөлд тайлбарлах, ойлгоход ХУРААНГУЙ шаардаагүй бол баримт бичиг, тайлагналын хэл нь англи хэл байна.

- Техникийн ур чадвар, чадавх:

- Зөвлөх компани нь нүүрсхүчлийн хийн зах зээлийн талаар гүнзгий ойлголттой гэдгээ батлах шаардлагатай бөгөөд үүнд нүүрсхүчлийн хийг саармагжуулах төсөл боловсруулах, нүүрсхүчлийн хийн кредитийн стандарт, магадлан шалгах механизм зэрэг болно.

- Ажил хариуцах баг нь ойн менежмент, газрын ашиглалт болон төлөвлөлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний чиглэлээр техникийн мэдлэг чадвартай, олон улсын шилдэг туршлага, стандартын талаар мэдлэгтэй байх ёстой.

- Санхүүгийн загварчлал, зардал-үр ашгийн шинжилгээ, хөрөнгө оруулалтын үнэлгээ зэрэг эдийн засаг, санхүүгийн дүн шинжилгээ хийж байсан туршлагатай байх нь нэн чухал.

- Зөвлөх компани нь шаардлагатай бол төслийн удирдлага, санхүү, хуулийн зөвлөгөө, хүрээлэн буй орчин судлал, оролцогч талуудын оролцоо зэрэг чиглэлээр мэргэшсэн, олон өөр чиглэлийн мэргэжилтнүүдийн хамтарсан баг томилон ажиллуулах чадвартай байх ёстой.

- Бэлэн байдал, үүрэг хариуцлага:

- Зөвлөх компани нь [Эхлэх огноог оруулах]-ны/ний дотор төслийн ажлыг эхлүүлэхэд бэлэн байх ёстой бөгөөд тохиролцсон хугацаанд ажил гүйлгээний зөвлөх үйлчилгээг дуусгавар болгох үүрэг хүлээнэ.

- Зөвлөх компани нь ажлын даалгаврын дагуу өндөр үр бүтээлтэй үр дүнд цаг тухайд нь хүрэхийн тулд хүний нөөц болон бусад нөөцийг хангалттай хэмжээнд хуваарилах ёстой.

- Зөвлөх компанийг тухайн төсөлд хангалттай нөөц зориулахад нь сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа ашиг сонирхлын зөрчил, бусад зэрэгцсэн төсөл хөтөлбөрийг урьдчилан илрүүлэх ёстой.

- Тайлагнал, баримтжуулалт:

- Зөвлөх компани нь хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, давсан үе шат, тулгарсан бэрхшээл, санал болгож буй үйл ажиллагааны төлөвлөгөөний нарийвчилсан баримт бичиг зэрэг явцын тайлангуудыг тогтмол гаргаж өгөх үүрэгтэй.

- Тайлан, танилцуулга, техникийн баримт бичиг зэрэг төслийн бүх баримт бичиг, үр дүнг ЕХ-ны формат, баримт бичгийн стандартын дагуу ирүүлсэн байх ёстой.

- Төсөв ба зардал:

- Зөвлөх компани нь гүйлгээний үйл ажиллагааны зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зөвлөх үйлчилгээний төлбөр, аяллын зардал болон бусад урьдчилан тооцоолсон зардлуудыг тусгасан төсөв, зардлын нарийвчилсан саналыг ирүүлэх шаардлагатай.

- Санал болгож буй төсөв нь төслийн нарийн төвөгтэй байдал, цар хүрээ, зөвлөх компанийн туршлага, чадавхыг харгалзсан, бодитой, ил тод, өрсөлдөхүйц байх шаардлагатай.

- Мэдээлэл хамгаалах дүрэм журмыг дагаж мөрдөх:

- Зөвлөх компани нь төсөлтэй холбоотой бүх өгөгдөл, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, ЕХ-ны өгөгдөл хамгаалах дүрэм журмыг дагаж мөрдөх шаардлагатай.

- Төслийн явцад цуглуулсан эсвэл боловсруулсан аливаа хувийн мэдээллийг холбогдох өгөгдөл хамгааллын хууль тогтоомжийн дагуу зохицуулах ёстой.

- Гэрээ:

- Зөвлөх компани нь төслийн оролцогч талуудтай ажиллах болзол, нөхцөлүүд, түүний дотор үр дүн, хугацаа, төлбөрийн хуваарь, маргаан шийдвэрлэх механизм зэргийг тусгасан албан ёсны гэрээ байгуулах хүсэлтэй байх шаардлагатай.

- Гэрээний төслийг ЕХ-ны худалдан авах ажиллагааны удирдамжийн дагуу боловсруулж, төслийн удирдах хороо эсвэл холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах ёстой.

- Тайлагнал:

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хүрсэн үе шат, тулгарсан саад бэрхшээл, санал болгосон үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг явцын дэлгэрэнгүй тайланг Найрамдал төсөлд тогтмол хугацаатай гаргаж өгөх.

Төсөл хэрэгжих байршил: Дархан-Уул аймаг

Тендерийн бичиг баримт хүлээн авах хугацаа, байршил: 2024 оны 8-р сарын 25 -ны 17.00 цаг хүртэл uuganzaya.ts@darkhan.gov.mn хаягаар цахимаар, мөн хэвлэмлээр Дархан-Уул аймаг, Дархан сум, Дархан-ХААИС-ийн байр, 213 тоот, Европ-Дарханы инновац энтрепренершип төв-д хүлээн авна.

Хамрах хүрээ: Монгол Улс, Европын холбооны гишүүн орнууд болон азийн орнуудаас төсөл хэрэгжүүлэх өндөр ур чадвартай туршлага, чадавхтай байгууллага, консорциум, баг тэгш эрхтэйгээр оролцох боломжтой.

Тендерийн материал илгээсэн бол +976 70373737 утсаар холбогдож мэдэгдэнэ.

“НАЙРАМДАЛ” ТӨСӨЛ

1. “Найрамдал” төслийн товч мэдээлэл:

Дараах линкээр орж төслийн талаарх мэдээллийг авна уу <https://eudarkhan.mn/>

Бүрдүүлэх бичиг баримт

Монгол Улс, Европын холбооны гишүүн орнууд болон азийн орнуудаас төсөл хэрэгжүүлэх өндөр ур чадвартай туршлага, чадавхтай байгууллага, консорциум, багийг Сайн дурын нүүрсхүчлийн хийн зах зээл (VCM) болон Парисын хэлэлцээрийн 6-р зүйлийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтад материал ирүүлэхийг урьж байна. Төсөл хэрэгжүүлэх сонгон шалгаруулах тендерт материал ирүүлэх байгууллага нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Оролцогчдод тавигдах шаардлага (Хавсралт-1)
2. Дээрх тендерийн бичиг баримтад дурдсан ажлын даалгаврын дагуу төслийн санал боловсруулан ирүүлэх

Төслийг хэрэгжүүлэх “Найрамдал” төслийн нийт төсөв: 35,000 хүртэлх евро байна.

2. Тендерийн санал илгээх

- 2.1 Алхам-1 Төслийн саналаа бэлтгэн хэвлэж ирүүлэхдээ дугтуйнд хийн битүүмжилж дурдсан хаягаар ирүүлнэ.
- 2.2 Алхам-2 Төслийн саналаа бэлтгэн PDF форматад оруулан дурдсан цахим хаяг руу илгээнэ.

3. Төслийн саналаа буцаан татах хүсэлт

Төслийн саналаа буцаан татахыг хүсвэл төсөл хүлээн авах сүүлчийн хугацаанаас хойш 7 хоногт багтаан тухайн санал илгээсэн и-мэйл хаяг болон утсаар давхар холбогдон хүсэлт гаргана. Мөн эрх бүхий төлөөлөгчөөр дамжуулан биечлэн татан авч болно.

4. Төслийн саналыг өөрчлөх

Төслийн санал хүлээн авсны дараа өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд аливаа өөрчлөлтийг шийдвэрийг “Найрамдал” төсөл гаргах эрхтэй.

5. Төслийг үнэлэх, сонгон шалгаруулах

- 5.1 Үнэлгээг хоёр үе шаттай зохион байгуулна. Нэгдүгээр шатанд төслийн баримт бичгийн үнэлгээ хийгдэнэ.
- 5.2 Хоёрдугаар шатанд нэгдүгээр шатанд тэнцсэн байгууллагуудад төсөл хүлээн авах сүүлчийн хугацаанаас хойш 10 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэх ба тендерийн комисс нэгдүгээр шатанд тэнцсэн байгууллагуудын үйл ажиллагааг нарийвчлан судалж ярилцлага хийсний үндсэн дээр сонгон шалгаруулалтыг хийн хариуг мэдэгдэнэ.
- 5.3 Шаардлага хангасан 2 төслийг сонгон шалгаруулна.
 - 4.1 Ус, хог хаягдал, эрчим хүчний чиглэлийн (нийгмийн дэд бүтцийг бий болгох)-1
 - 4.2 Нийгэм, мэдээллийн технологийн энтрепренершипыг дэмжих төсөл -1

5.4

6. Хэлэлцээр хийх

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллага, консорциум, баг нь төслийн саналд дурдсан ажил, төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхтэй холбоотой хэлэлцээрийг “Найрамдал” төсөлтэй хийнэ.

Хэлэлцээрийн дараагийн шат болох тухайн байгууллага/ консорциумтай гэрээг байгуулах асуудлыг “Найрамдал” төсөл эцэслэн шийдвэрлэнэ.

7. Төслийн гэрээний нөхцөл тодорхойлолт

7.1 “Найрамдал” төсөл нь аливаа саналыг хүлээн авах татгалзах эрхтэй

7.2 “Найрамдал” төсөл нь төслийн гэрээ байгуулахдаа хүсэлт гаргагч байгууллагын саналыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хүлээн авах, харилцан тохиролцоо эрхтэй.

7.3 Энэ зард дурдсан мэдээллийн үнэн зөв байдлыг “Найрамдал” төсөл хариуцах бөгөөд сонгон шалгаруулах тендерийн зарын утга агуулгад ямар нэгэн өөрчлөлт орж байгаа тохиолдолд олон нийтэд болон оролцогчдод нэн даруй мэдээлнэ.

7.4 Сонгон шалгаруулалтын хүрээнд ирсэн төслийн мэдээллийн нууцыг чандлан хадгална.

7.5 Гэрээний хугацаанд хийгдсэн ажлууд, агуулга, үйлчилгээ төслийн хугацаанд “Найрамдал” төслийн өмч байх бөгөөд гэрээ байгуулагч этгээд төслийн мэдээлэлтэй холбоотой аливаа нууцыг чандлан хадгална.

8. **Төслийн хэрэгжилтийн тайлан:** Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн хугацааны турш үйл ажиллагааны хэрэгжилтийг “Найрамдал” төсөлд тайлагнана. Тайлангийн хугацаа, хэлбэрийг гэрээнд нарийвчлан тусгана.

Хавсралт-1 Оролцогчдод тавигдах шаардлага

№	Тавигдах шаардлага	Нотлох баримт
1	Хуулийн этгээд байх / баг	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/ хамтын ажиллагааны гэрээ
2	Ажлын туршлага	Өмнө хийж байсан ижил төстэй ажлуудын нотлох баримт материал тодорхойлолт, байгууллагын холбогдох туршлага, чадавхыг харуулсан үйл ажиллагааны тайлан
3	Хүний нөөцийн чадамж	Санал болгож буй төслийн багийн бүрэлдэхүүний танилцуулга (CV)
4	Шүүхийн маргаангүй байна.	Шүүхийн архивын лавлагаа (тодорхойлолт)
5	Албан мэдэгдэл ирүүлэх	Оролцогчийн ирүүлсэн үнийн санал үр дүнг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй, шалгуурт нийцүүлэн ажил үйлчилгээг бүрэн гүйцэтгэх баталгааг албан бичгээр ирүүлэх
6	Иргэний үнэмлэхийн хуулбар	Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар
7	Харилцагч банкны тодорхойлолт	Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тодорхойлолт